



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол шуудан ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй
тайлан

Аудитын код: СНАГ-2025/033/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас:260949 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn
Аудитор: О.Наранбат
Утас: 261628 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ниямазон аудит ХХК-ийн захирал
З.Цээнээ
Утас: 70145906 Цахим хаяг: audit@nmz.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.17 № 07/1062
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол шуудан ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсад анх удаа Дэлхийн шуудан холбооны Ази номхон далайн бүсийн стратеги форумыг зохион байгуулан оролцож, олон талт болон хоёр талт хамтын ажиллагааны хэлэлцээрүүдийг БНХАУ, БНЭУ, Япон, БНСУ-ын шуудангийн байгууллагуудтай хийсэн байна.

Аудитын гол асуудал

Монгол шуудан ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 23/14 дүгээр тогтоолоор эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг баталж, 2024 оны 03 дугаар сарын 24/03 дугаар тогтоолоор тодотгон нийт орлогыг 23,750.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 23,700.0 сая төгрөгөөр, 50.0 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2,515.5 сая төгрөгийг баталсан байна.

Гүйцэтгэлээр 24,395.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 24,226.9 сая төгрөгийг зарцуулж, 168.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Компани нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	16,148,550,148.05	9,747,235,665.60
1.1.2	Дансны авлага	2,667,175,998.76	5,487,178,266.86
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	135,689,028.00	36,704,950.48
1.1.4	Бусад авлага	143,565,228.09	322,059,493.58
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	3,498,586,855.77	4,417,731,167.56
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,978,395,671.53	5,529,320,145.79
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	27,571,962,930.20	25,540,229,689.87
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	8,495,852,792.93	9,441,368,255.49
1.2.2	Биет бус хөрөнгө	2,308,742,471.37	2,047,471,887.52
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	500,000.00	500,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,805,095,264.30	11,489,340,143.01
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	38,377,058,194.50	37,029,569,832.88
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	10,459,357,649.33	9,241,178,117.76
2.1.1.2	Цалингийн өглөг	230,582,579.90	313,398,175.31
2.1.1.3	Татварын өр	134,928,454.27	14,531,702.64
2.1.1.4	НДШ-ийн өглөг	14,161,569.68	9,467,299.76
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	917,222,935.68	903,683,527.95
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	473,428,527.19	922,645,541.04
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,229,681,716.05	11,404,904,364.46
2.2	Өр төлбөрийн нийт дүн	12,229,681,716.05	11,404,904,364.46
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	6,572,700,000.00	6,572,700,000.00
2.3.2	-хувийн	3,385,936,300.00	3,385,936,300.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	2,538,512,210.45	2,538,512,210.45
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,379,919,523.85	3,379,919,523.85
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	3,714,085,782.53	3,714,085,782.53
2.3.9	Хуримтлагдсан ашиг	6,556,222,661.62	6,033,511,651.59
2.3.11	Эздийн өмчийн дүн	26,147,376,478.45	25,624,665,468.42
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	38,377,058,194.50	37,029,569,832.88

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	19,369,578,379.77	23,894,295,918.89
2	Борлуулалтын өртөг	21,526,001,245.47	21,896,067,590.24
3	Нийт ашиг(алдагдал)	(2,156,422,865.70)	1,998,228,328.65
4	Түрээсийн орлого	137,959,815.10	164,107,952.36
5	Хүүний орлого	460,898,494.38	333,109,948.54
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,525,406,320.67	1,659,968,499.94
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	238,476,875.16	388,334,496.64
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	5,393,800,778.03	(282,537,513.96)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	35,498,459.38	3,999,999.91
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,107,851,485.36	168,605,718.92
19	Орлогын татварын зардал	140,136,455.05	32,587,849.41
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,967,715,030.31	136,017,869.51
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,967,715,030.31	136,017,869.51
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдалтай)	1,967,715,030.31	136,017,869.51

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	4,300,458,597.23	4,814,083,519.71	24,991,610,151.24
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					1,967,715,030.31	1,967,715,030.31
6	Өмчид гарсан өөрчлөлт				(586,372,814.70)		(586,372,814.70)
7	Зарласан ногдол ашиг					(225,575,888.40)	(225,575,888.40)
9	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	3,714,085,782.53	6,556,222,661.62	26,147,376,478.45
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					(658,728,879.54)	(658,728,879.54)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					136,017,869.51	136,017,869.51
17	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	3,714,085,782.53	6,033,511,651.59	25,624,665,468.42

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	103,925,063,975.29	47,748,461,279.24
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	15,540,296,005.08	19,057,075,693.81
	Бусад мөнгөн орлого	88,384,767,970.21	28,691,385,585.43
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	106,430,984,826.27	51,804,660,538.26
	Ажиллагчдад төлсөн	8,075,806,596.46	9,263,002,414.59
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,483,989,133.86	2,600,292,451.72
	Бараа материал худалдан авахад төлсөн	2,278,190,902.30	3,116,829,696.22
	Ашиглалтын зардалд төлсөн	1,882,203,696.27	5,527,243,153.32
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,605,436,850.60	4,264,220,533.57
	Татварын байгууллагад төлсөн	1,511,026,301.00	1,569,937,639.86
	Даатгалын төлбөрт төлсөн	122,993,711.52	84,999,772.09
	Бусад мөнгөн зарлага	86,471,337,634.26	25,378,134,876.89
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,505,920,850.98)	(4,056,199,259.02)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	650,725,627.87	131,670,064.95
	Хүлээн авсан хүүний орлого	650,725,627.87	131,670,064.95
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,168,349,927.20	1,367,339,065.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,079,908,727.20	1,280,905,165.00
	Биет бус хөрөнгө хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	88,441,200.00	86,433,900.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,517,624,299.33)	(1,235,669,000.05)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	221,219,675.23	586,912,851.70
	Төлсөн ногдол ашиг	221,219,675.23	586,912,851.70
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(221,219,675.23)	(586,912,851.70)
4	Валютын ханшийн зөрүү	1,007,333,094.51	(522,533,371.68)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(3,237,431,731.03)	(6,401,314,482.45)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,385,981,879.08	16,148,550,148.05
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,148,550,148.05	9,747,235,665.60

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон

/сая.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
			1	2	3	4=2-3	5
1.	Нийт орлого	сая.төг	25,397.7	23,750.0	24,395.5	(645.5)	102.7
2.	Нийт зардал	сая.төг	23,289.9	23,700.0	24,226.9	(526.9)	102.2
3.	Татварын өмнөх ашиг	сая.төг	2,107.8	50.0	168.6	(118.6)	337.2
4.	Орлогын татварын зардал	сая.төг	140.1	5.0	32.6	(27.6)	652.0
5.	Цэвэр ашиг	сая.төг	1,967.7	45.0	136.0	(91.0)	302.0
6.	Нийт ажиллагсад	хүн	956	980	961	19	98.1
7.	Цалингийн сан	сая.төг	10,114.7	10,700.0	10,864.0	(164.0)	101.5
8.	Нийт авлага	сая.төг	2,946.4	2,500.0	5,845.9	(3,345.9)	233.8
9.	Нийт өр төлбөр	сая.төг	12,229.7	6,500.0	11,404.9	(4,904.9)	175.5
10.	Нийт хөрөнгө оруулалт	сая.төг	975.8	2,515.5	1,743.3	772.2	69.3
11.	Ногдол ашиг	сая.төг	597.2	13.5	99.8	(86.3)	739.3
12.	Элэгдлийн зардал	сая.төг	1,170.2	1,400.0	1,540.0	(140.0)	110.0

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 83.8 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
					Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүү байдлын тайлангийн нийт хөрөнгө, өр төлбөр ба эздийн өмчийн эхний үлдэгдлийг өмнөх оны аудит хийгдсэн санхүү байдлын тайлангийн эцсийн үлдэгдлээс 83.7 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.	1	83,774.6	1	83,774.6	1	83,774.6		
Дүн	1	83,774.6	1	83,774.6	1	83,774.6		

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Монгол шуудан ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

3.2 Аудитаар нийт 30.2 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 2.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 3.8 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 24.2 сая төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орон нутаг дахь салбарын дарга нарын тэмцээнд орох зардлын зориулалтаар олгосон 2.2 сая төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүй томилолтын зардалд бүртгэсэн.	1	2,214.6	1	2,214.6								
Тайлант онд гадаадад суралцаж буй гэх үндэслэлээр 2 ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг үндсэн ажилтны кодоор төлсөн боловч хүний нөөцийн албанд ямар нэг шийдвэр, нотлох баримт байхгүй байна.	1	3,801.6			1	3,801.6						
Гүйцэтгэх захирлын 2024 оны А/101 дүгээр тушаалын дагуу жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийж, тайлагнасан боловч тооллогын комисс нь эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсан үндсэн хөрөнгө, түүхий эд материалын жагсаалт гаргаагүй, үүргээ бүрэн биелүүлээгүй, сери маркийн агуулахын тооллогыг хийгээгүй байна.	1	-			1	-						

Монгол шуудан ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

Тайлант оны нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан болон цахим төлбөрийн баримтын системийн НӨАТ-ын дүн 24.2 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан.	1	24,205.8					1	24,205.8			
Дүн	4	30,222.0	1	2,214.6	2	3,801.6	1	24,205.8			

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар нийт 43.3 сая төгрөгийн 7 зөрчил илэрснээс 12.7 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 8.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 21.7 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/						
			Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Комплайнсын хяналт, үнэлгээний тайлангаар "мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой эрсдэл өндөр үйл ажиллагааны хориг арга хэмжээнд орох магадлал их байгаа тул шуудангийн байгууллагыг мөнгөн гуйвуулгын үйлчилгээ хийхийг хориглосны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлага байна" гэсэн зөвлөмж өгчөө. Гэтэл 2024 оны 11 дүгээр сарын 27-нд Ард Кредит ББСБ-аар 61018.66 еврогийн мөнгөн гуйвуулгын гүйлгээг хийсэн байна.	1	-						1	-
Иргэнтэй байгуулсан "Үйл ажиллагааны дүрэм, журам боловсруулах үйлчилгээ үзүүлэх" 291/24 дугаар гэрээнд заагдсан ажлаас "Ажлын бүтэн бус цагаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээний үлгэрчилсэн загвар"-с өөр ажил хүлээн аваагүй, гэрээний үүргийн биелэлтийг хангуулаагүй байна.	1	16,000.0						1	16,000.0
Тус компанийн хуулийн хэлтэс 434 гэрээний төсөл боловсруулан хянаж гэрээ байгуулсны 19 нь утга агуулгын алдаатай, нэг ижил төрлийн үйл ажиллагаанд өөр өөр гэрээний төслүүд ашигласан, гэрээ хянах, бүртгэх үйл ажиллагааг журамлаагүй байна.	1	-						1	-
БНХАУ-ын Erlian Munkhiin Import and Export Corporation байгууллагатай худалдах, худалдан авах гэрээ байгуулан нийт 42.5 сая төгрөг	1	6,587.5			1	6,587.5			

Монгол шуудан ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

шилжүүлсэн байна. Эдгээр бараа бүтээгдэхүүнийг Монгол Улсын гаалиар мэдүүлж, гааль болон НӨАТ төлөөгүй, бараа хүлээлцэх цэгийг гэрээ болон нэхэмжлэлд өөрөөр тусгасан байна.								
БНХАУ-ын Erlian Munkhiin Import and Export Corporation байгууллагаас худалдан авсан бараанаас 5.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй.	1	5,725.4					1	5,725.4
Нүбисофт ХХК-тай 19.8 сая төгрөгийн 243/24 дугаар гэрээний ажил гүйцэтгэх хугацааг 21 хоногоор тогтоосон боловч гэрээг 60 хоног хэтрүүлэн гүйцэтгэжээ. Гэвч гэрээний дагуу өдрийн 0.5 хувиар алданги тооцоогүй байна.	1	6,138.0	1	6,138.0				
Иргэнтэй 4.0 сая төгрөгийн 203/24 дугаар гэрээ, Баян трейвэл лодж ХХК-тай хамтран ажиллах 4.9 сая төгрөгийн 332/24 дугаар гэрээнүүдийг анхан шатны баримтын бүрдэлгүй байхад төлбөрийг нь хийсэн байна.	1	8,933.5			1	8,933.5		
Дүн	7	43,384.4	2	12,725.5	1	8,933.5	4	21,725.4